ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2025/17/НА-СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дундговь аймаг<br>2025 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох<br>Утас: 70592439<br>Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn<br><br>Аудитын менежер:  Т.Оюун-Эрдэнэ<br>Утас: 70592225<br>Цахим хаяг: Oyun-erdenet@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Т.Батсайхан<br>Утас: 70593113<br>Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**0**

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ... 2**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ... 4**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 4**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 5**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 6**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 7**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 8**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 9**

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ... 10**

5.1 **Төлбөрийн акт** ... 10

5.2 **Албан шаардлага** ... 10

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ... 16**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.02.25 № 48

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ЛХАГВАБААТАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын аудитаар илэрсэн 68.2 сая төгрөгийн зөрчлүүд нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 2.4 сая төгрөгөөр илүү байна.

Дээрх зөрчлүүд нь Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-т, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т, Төрийн албан тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/", 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам",-д заасан заалтуудтай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, бүх төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг олгож эхэлсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 981.7 сая төгрөгөөр өссөн байна. Мөн орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил ажилласны тэтгэмжийг төрийн захиргааны албан

4825020160

хаагчдад олгож эхэлснээр 2024 онд 18 албан хаагч 137.5 сая төгрөгийн дэмжлэг авсан байна.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

**Аудитын гол асуудал**

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/246 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд албан хаагчдад 147.0 сая төгрөгийн эрүүл мэнд болон орон нууцны дэмжлэг олгосон нь тайлант үеийн өндөр үнэлгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 36 зорилт, 120 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 88.9 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 579,720,183.13 | 656,143,679.23 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 21,377,420.81 | 21,518,446.31 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 21,377,420.81 | 21,518,446.31 |
| 3121 | Төгрөг | 21,377,420.81 | 21,518,446.31 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 21,377,420.81 | 21,518,446.31 |
| 33 | АВЛАГА | 174,438,124.00 | 164,074,124.00 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 230,000.00 | 230,000.00 |
| 332 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 3,282,980.00 | 6,488,980.00 |
| 335 | Бусад авлага | 170,925,144.00 | 157,355,144.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 77,480,068.00 | 63,910,068.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 93,445,076.00 | 93,445,076.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 383,904,638.32 | 464,581,108.92 |
| 351 | Түүхий эд материал | 108,480.00 | 108,480.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 108,480.00 | 108,480.00 |
| 354 | Хангамжийн материал | 383,796,158.32 | 464,472,628.92 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 4,138,925.00 | 3,487,885.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 321,507,200.32 | 390,634,885.92 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 1,875,000.00 | 17,085,000.00 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 15,581,143.00 | 11,066,100.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 37,643,890.00 | 38,017,290.00 |
| 3546 | Хүнсний материал | 3,050,000.00 | 4,181,468.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | 5,970,000.00 |
| 363 | Тэжээлийн нөөц | | 5,970,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 12,411,748,205.32 | 12,211,745,385.14 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12,411,748,205.32 | 12,211,745,385.14 |
| 392 | Биет хөрөнгө | 9,023,929,908.48 | 8,818,306,288.30 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 8,991,110,666.61 | 9,323,413,475.61 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,106,500,029.26) | (1,397,557,252.04) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 601,900,000.00 | 605,850,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (464,319,444.16) | (504,066,666.58) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,542,569,213.08 | 1,609,252,378.99 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (946,019,046.98) | (1,133,611,170.70) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 526,280,729.91 | 552,247,160.91 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (331,992,631.67) | (392,391,272.98) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 340,527,900.00 | 340,527,900.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (129,627,449.05) | (185,358,264.91) |
| 393 | Биет бус хөрөнгө | 3,387,818,296.84 | 3,393,439,096.84 |
| 39301 | Програм хангамж | 120,557,725.00 | 120,557,725.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (90,459,428.16) | (90,459,428.16) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,357,720,000.00 | 3,363,340,800.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 12,991,468,388.45 | 12,867,889,064.37 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 47,046,606.00 | 39,785,119.57 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 47,046,606.00 | 39,785,119.57 |
| 413 | Өглөг | 47,046,606.00 | 39,785,119.57 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 2,100,512.57 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 47,046,606.00 | 37,684,607.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 12,944,421,782.45 | 12,828,103,944.80 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 12,944,421,782.45 | 12,828,103,944.80 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 5,556,641,311.61 | 5,556,641,311.61 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 5,556,641,311.61 | 5,556,641,311.61 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 4,565,444,720.63 | 4,449,126,882.98 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 4,565,444,720.63 | 4,573,444,720.63 |

| | | | |
|---|---|---|---|
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | (124,317,837.65) |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,822,335,750.21 | 2,822,335,750.21 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 12,991,468,388.45 | 12,867,889,064.37 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 4,042,977,431.01 | 6,870,866,085.51 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 354,000,442.81 | 855,107,605.31 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 354,000,442.81 | 855,107,605.31 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 16,486,607.81 | 38,813,941.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 304,500.00 | 14,767,668.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 16,182,107.81 | 24,046,273.50 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 276,928,835.00 | 343,622,165.91 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 60,585,000.00 | 472,671,497.90 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,688,976,988.20 | 6,015,758,480.20 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 440,477,788.20 | 385,291,480.20 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 182,241,400.00 | 238,314,384.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 83,634,354.00 | 100,592,052.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 174,602,034.20 | 46,385,043.70 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 3,248,499,200.00 | 5,630,467,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 3,248,499,200.00 | 5,630,467,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 4,531,408,265.92 | 6,584,203,940.26 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,531,408,265.92 | 6,584,203,940.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,296,515,372.50 | 5,986,017,724.59 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,490,791,200.46 | 2,472,044,520.63 |
| 210101 | Үндсэн цалин | 871,555,341.02 | 1,287,234,381.63 |
| 210102 | Нэмэгдэл | 442,388,424.00 | 945,828,739.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,053,515.44 | 78,565,000.00 |
| 210104 | Урамшуулал | 108,793,920.00 | 160,416,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 174,906,391.23 | 284,237,810.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 119,135,845.59 | 193,304,269.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,017,673.00 | 23,100,433.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,161,159.26 | 11,533,243.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,599,948.82 | 10,594,152.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,991,764.56 | 45,705,712.81 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 266,198,455.52 | 295,453,009.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,345,019.52 | 32,971,237.99 |
| 210302 | Түлш, халаалт | 225,389,612.00 | 244,332,905.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,463,824.00 | 18,148,866.08 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 150,548,503.27 | 270,530,902.36 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,603,016.00 | 18,688,310.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 76,545,868.00 | 121,691,851.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,878,907.37 | 11,534,162.76 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 147,456.00 | 161,320.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 51,373,255.90 | 118,455,258.40 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 95,548,596.00 | 145,624,550.00 |
| 210604 | Урсгал засвар | 95,548,596.00 | 145,624,550.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 67,911,700.00 | 92,386,852.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 67,911,700.00 | 92,386,852.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 99,282,118.20 | 53,928,735.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 84,776,404.00 | 39,317,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,251,250.00 | 5,251,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 351,711.20 | 461,061.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 145,349.60 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,199,000.00 | 7,872,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 593,753.00 | 882,074.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,951,328,407.82 | 2,371,811,344.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,219,704,220.00 | 1,701,050,730.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 48,435,840.00 | 34,734,588.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 683,188,347.82 | 636,026,026.09 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 234,892,893.42 | 598,186,215.67 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 197,918,521.00 | 550,171,465.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | 10,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,173,600.00 | 8,982,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 46,553,900.00 | 91,520,386.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 185,536,072.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 144,191,021.00 | 254,132,607.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 36,974,372.42 | 48,014,750.67 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,974,372.42 | 48,014,750.67 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (488,430,834.91) | 286,662,145.25 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 301,832,628.09 | 410,979,982.90 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 212,542,053.40 | 6,000,000.00 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | | 6,480,000.00 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 89,290,574.69 | 398,499,982.90 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (301,832,628.09) | (410,979,982.90) |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (790,263,463.00) | (124,317,837.65) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 3,729,880,561.01 | 6,053,366,421.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 40,903,572.81 | 37,607,941.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 40,903,572.81 | 37,607,941.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 40,903,572.81 | 37,607,941.50 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 304,500.00 | 14,767,668.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,530,602.00 | 22,840,273.50 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,688,976,988.20 | 6,015,758,480.20 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 440,477,788.20 | 385,291,480.20 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 182,241,400.00 | 238,314,384.50 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 83,634,354.00 | 100,592,052.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 174,602,034.20 | 46,385,043.70 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 3,248,499,200.00 | 5,630,467,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 3,248,499,200.00 | 5,630,467,000.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 3,684,553,140.20 | 6,046,987,742.20 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,684,553,140.20 | 6,046,987,742.20 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,429,660,246.78 | 5,448,801,526.53 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,488,090,076.46 | 2,469,683,015.06 |
| 210101 | Үндсэн цалин | 871,555,341.02 | 1,284,872,876.06 |
| 210102 | Нэмэгдэл | 442,388,424.00 | 945,828,739.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 65,352,391.44 | 78,565,000.00 |
| 210104 | Урамшуулал | 108,793,920.00 | 160,416,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 174,906,391.23 | 284,237,810.44 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 119,135,845.59 | 193,304,269.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,017,673.00 | 23,100,433.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,161,159.26 | 11,533,243.21 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,599,948.82 | 10,594,152.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,991,764.56 | 45,705,712.81 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 236,034,588.52 | 295,603,009.87 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,345,019.52 | 32,971,237.99 |
| 210302 | Түлш, халаалт | 195,225,745.00 | 244,332,905.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,463,824.00 | 18,298,866.08 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 137,778,785.37 | 204,583,273.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,999,296.00 | 18,037,920.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 78,338,482.00 | 123,307,547.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,878,907.37 | 11,534,162.76 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 147,456.00 | 161,320.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 36,414,644.00 | 51,542,324.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 96,397,446.00 | 234,947,785.00 |
| 210604 | Урсгал засвар | 83,997,446.00 | 234,947,785.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 67,911,700.00 | 92,386,852.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 67,911,700.00 | 92,386,852.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 70,930,943.20 | 56,758,595.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 56,425,229.00 | 42,146,860.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,251,250.00 | 5,251,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 351,711.20 | 461,061.60 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 145,349.60 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,199,000.00 | 7,872,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 593,753.00 | 882,074.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,151,616,316.00 | 1,810,601,185.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,103,001,476.00 | 1,771,866,597.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 48,614,840.00 | 38,734,588.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 254,892,893.42 | 598,186,215.67 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 217,918,521.00 | 550,171,465.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 20,000,000.00 | 10,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,173,600.00 | 8,982,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 46,553,900.00 | 91,520,386.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 185,536,072.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 144,191,021.00 | 254,132,607.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 36,974,372.42 | 48,014,750.67 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,974,372.42 | 48,014,750.67 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 45,327,420.81 | 6,378,679.50 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 23,950,000.00 | 28,466,705.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 23,950,000.00 | 28,466,705.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23,950,000.00 | 28,466,705.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (23,950,000.00) | (28,466,705.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 21,377,420.81 | (22,088,025.50) |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 21,377,420.81 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 21,377,420.81 | 21,518,446.31 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,556,641,311.61 | 2,822,335,750.21 | 5,355,708,183.63 | 13,734,685,245.45 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 5,556,641,311.61 | 2,822,335,750.21 | 5,355,708,183.63 | 13,734,685,245.45 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | (790,263,463.00) | (790,263,463.00) |
| 10 | 2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 5,556,641,311.61 | 2,822,335,750.21 | 4,565,444,720.63 | 12,944,421,782.45 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | (124,317,837.65) | (124,317,837.65) |
| 19 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 5,556,641,311.61 | 2,822,335,750.21 | 4,449,126,882.98 | 12,828,103,944.80 |
| | | | | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,637,467,000.00 | 5,622,887,964.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,637,467,000.00 | 5,622,887,964.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 5,113,700,000.00 | 5,099,164,499.12 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,438,939,800.00 | 2,438,939,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,264,346,300.00 | 1,264,346,300.00 |
| 210102 | Нэмэгдэл | 941,728,100.00 | 941,728,100.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 73,549,000.00 | 73,549,000.00 |
| 210104 | Урамшуулал | 159,316,400.00 | 159,316,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 283,668,100.00 | 280,466,336.08 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 193,182,400.00 | 190,737,280.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22,900,800.00 | 22,798,435.72 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,440,000.00 | 11,382,242.89 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,650,100.00 | 10,443,151.84 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 45,494,800.00 | 45,105,224.75 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 295,305,800.00 | 295,305,671.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 32,673,900.00 | 32,673,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 244,333,000.00 | 244,332,905.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 18,298,900.00 | 18,298,866.08 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 154,767,500.00 | 152,169,878.96 |
| 210401 | Бичиг хэрэг | 18,228,400.00 | 18,223,420.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 73,491,500.00 | 73,489,997.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,534,600.00 | 11,534,162.76 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,723,000.00 | 161,320.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 48,790,000.00 | 48,760,979.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 244,507,000.00 | 244,086,585.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,250,000.00 | 8,249,800.00 |
| 210602 | Тавилга | 2,900,000.00 | 2,889,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 233,357,000.00 | 232,947,785.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 92,566,800.00 | 92,556,852.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 92,566,800.00 | 92,556,852.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 48,550,000.00 | 44,703,735.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 33,887,300.00 | 30,092,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,260,000.00 | 5,251,250.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 496,500.00 | 496,411.20 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 118,300.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,905,000.00 | 7,872,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 882,900.00 | 882,074.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,555,395,000.00 | 1,550,935,640.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,538,475,000.00 | 1,534,751,910.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,920,000.00 | 16,183,730.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 523,767,000.00 | 523,723,465.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 523,767,000.00 | 523,723,465.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,983,000.00 | 8,982,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 91,521,300.00 | 91,520,386.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 185,543,300.00 | 185,536,072.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 227,719,400.00 | 227,684,607.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,637,467,000.00 | 5,629,187,964.12 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 5,630,467,000.00 | 5,611,810,464.12 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 5,630,467,000.00 | 5,611,810,464.12 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 7,000,000.00 | 17,377,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 14,767,668.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,000,000.00 | 2,609,832.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **405,291,480.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **405,291,480.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 349,485,265.41 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 30,878,820.06 |
| 210101 | Үндсэн цалин | 20,662,181.06 |
| 210102 | Нэмэгдэл | 4,100,639.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,016,000.00 |
| 210104 | Урамшуулал | 1,100,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,771,474.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 2,566,988.12 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 301,997.54 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 151,000.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 151,000.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 600,488.06 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 297,337.99 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 297,337.99 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,277,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,817,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,460,240.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,127,905.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 14,127,905.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,254,860.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,254,860.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 230,877,078.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 208,326,220.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 22,550,858.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 55,806,214.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,448,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,448,000.00 |
| 2134 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 29,358,214.79 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 29,358,214.79 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 405,291,480.20 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 405,291,480.20 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 258,314,384.50 |

| | | |
|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 100,592,052.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 46,385,043.70 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 68,217.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 8,492.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 59,724.6 мянган төгрөгийн 7 албан шаардлагыг хүргүүллээ.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 68,217.1 мянган төгрөгийн зөрчил[1] илэрч, төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

- Төрийн сангийн ажилтнуудад үр дүнгийн 8,492.5 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгож төсөвт хохирол учруулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх */Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/* 15.1.3 дахь */Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/* тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Хохирлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.*

### 5.2 Албан шаардлага

- Санхүүгийн албан хаагчдын ажлыг дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 2,871.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д */Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 -т */улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох/*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 -д */Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно/* 15.1.3 -т */Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох/*, 15.2.6-д */байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох./*, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 -т */Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна/*

- Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалинг 80 хувиар тогтоож, **3,703.2** мянган төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, 16.5.2-т */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*, Хөдөлмөрийн тухай хуулийн 57.1. */Ажилтан үндсэн ажлын цагаас бусад цагт үндсэн ажил олгогчоос өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд үндсэн ажил олгогчдоо мэдэгдэх үүрэгтэй./*, 57.3.3-т */Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4-т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина./*, 84.4.-*т /Долоо хоногийн*

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна./* тус тус заасныг зөрчсөн байна.

- Тэтгэвэрт гарч хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон албан хаагчдад хөдөө орон нутагт ажилласны таван жилийн тэтгэмж **14,653.4**.мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Төрийн албан тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-*т /Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална/* заасныг тус тус зөрчсөн байна.

- Даргын албан үүргийг 3 сар түр орлон гүйцэтгүүлж ажил хавсарсны нэмэгдлийг 40 хувиар олгож **1,297.0** мянган төгрөгийн цалин олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 9 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам"-ын 2.2-т */Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно/* тус тус зөрчсөн байна.

- Орон сууцны дэмжлэг үзүүлсэн ажилтантай цаашид ажиллах гэрээ байгуулаагүй **10,000.0** мянган төгрөгийн тусламж олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6.4.1-т */төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, 16.5.2-т */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*;

- Албан хаагчдыг БНХАУ-д туршлага судлуулж тухайн зардлыг нэг удаагийн тэтгэмжийн зардлаас **18,700.0** мянган төгрөгийн төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т */Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т */Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/*, 20.2.3-т */холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах/*, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дугаар тушаалаар батлагдсан */Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын /Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд жил бүр албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор гадаад, дотоодод сургалтад хамруулахад шаардагдах сургалтын төлбөр, унаа, хоолны зардал, сургалттай холбогдсон материал бэлтгэх, багшийн хөлс төлөх, сургалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмж түрээслэх зэрэг энэ ангилалд бүртгэнэ/*. заасныг тус тус зөрчсөн.

- Баяр наадмын зардлыг төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс **8,500.0** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх */Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/*, Засгийн газрын 2010 оны 271 дугаар тогтоолын "Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /наадмын санхүүжилт/", Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь 1-д */Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай/* заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулсан этгээдээс авч хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

---

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Баяр наадмын зардлыг төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээнээс хэтрүүлэн зарцуулсан. | 1 | 8,500.0 | - | - | 1 | 8,500.0 | - | - | - | - |
| Төрийн сангийн ажилтнуудад хууль тогтоомжоор зөвшөөрөөгүй урамшууллыг үр дүнгийн мөнгөн урамшууллыг давхардуулан олгосон. | 1 | 8,492.5 | 1 | 8,492.5 | | | | | | |
| Санхүүгийн албаны ажилтнуудад үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр балансын урамшууллыг давхардуулан олгосон. | 1 | 2,871.0 | | | 1 | 2,871.0 | | | | |
| Тэтгэвэрт гарч хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон хүнд хөдөө орон нутагт ажилласны таван жилийн тэтгэмж олгосон. | 1 | 14,653.4 | | | 1 | 14,653.4 | | | | |
| Даргын албан үүргийг 3 сар түр орлон гүйцэтгүүлж ажил хавсарсны нэмэгдлийг 40 хувиар олгосон. | 1 | 1,297.0 | | | 1 | 1,297.0 | | | | |
| Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтны цалинг 80 хувиар тогтоож илүү цалин олгосон. | 1 | 3,703.2 | | | 1 | 3,703.2 | | | | |
| Албан хаагчдыг БНХАУ-д туршлага судлуулж гарсан зардлыг нэг удаагийн тэтгэмжийн зардлаас гаргасан. | 1 | 18,700.0 | | | 1 | 18,700.0 | | | | |
| Орон сууцны дэмжлэг үзүүлсэн ажилтантай цаашид ажиллах гэрээ байгуулаагүй. | 1 | 10,000.0 | | | 1 | 10,000.0 | | | | |
| **Дүн** | **8** | 68,217.1 | 1 | 8,492.5 | **7** | 59,724.6 | - | - | - | - |